



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 5795

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.8, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.4, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд жуулчид мэдээлэл авдаг www.ulaanbaatar.mn/en, www.ulaanbaatour.mn, www.ulaanbaatour.co.kr цахим хуудсуудын мэдээллийг шинэчлэх, шинээр боловсруулах, мэдээ орчуулж оруулах, техникийн шаардлагатай шинэчлэлийг хийх ажлыг “Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо”-той хууль, журамд нийцүүлэн гэрээ байгуулж гүйцэтгүүлэхийг Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /Б.Халиун/-д үүрэг болгосугай.

2. Гэрээт ажлын төлбөр болох 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА